



**САМӨГТОЙ
ТАНИЛЦ!**



Самөгийн тухай

НАС: 9
АМЬДАРДАГ ГАЗАР: Непал, Багмати муж
ХЭЛ: Непал, англи
ЗОРИЛГО, МӨРӨӨДӨЛ: 1) Нисгэгч болох. 2) Есүс Христийг дагах. 3) Анхны хүүгээ "Шрижал" буюу цэвэр ариун гэсэн утгатай нэрээр нэрлэх.
ГЭР БҮЛ: Самөг, Аама (ээж), Буба (аав), хоёр диди (эгч)

Самөг Есүсийг хэрхэн дагадаг вэ?

Христийн шашинтай хүн Непалд тийм ч олон биш. Олон хүн Есүс Христийн талаар огт мэддэггүй. Самөг Есүсийн тухай бусдад ярих дуртай.

Нэг удаа Самөгийн сургууль сурагчдадаа дэлхий дахин дахь баярын талаар суралцахад нь туслах зорилгоор Христийн мэндэлсний баярыг тэмдэглэв. Самөг Христийн шашинтай гэдгээ хуваалцжээ. Тэрээр багш нар, мөн ангийнхныхаа асуусан Есүсийн тухай асуултад хариулжээ.

"Би амьдралынхаа турш Есүс Христийг дагахыг хүсдэг" гэж Самөг хэлсэн. ●

ЗУРАГ-ЧИМЭГЛЭЛИЙГ ААРОН КӨШЛИ



Чи ч бас Есүсийг дагаж чадна!

Есүсийг дагах олон арга зам бий. Та нар Түүнийг хэрхэн дагадаг вэ? Бичээд бидэнд илгээгээрэй!

Самөгийн дуртай зүйл

ЕСҮСИЙН ТУХАЙ ТҮҮХ: Тэр бидэнд хайртай учраас бидний төлөө амиа өгсөн тухай түүх

ХҮҮХДИЙН ХЭСГИЙН ДУУ: "Бошиглогчийг дага" (Хүүхдийн дууны ном, 58)



ДУРТАЙ ГАЗАР: Гэрийнх нь зочны өрөө

ХООЛ: Бялуу ба кукхура (тахиа)



ӨНГӨ: Улбар шар, цэнхэр

ХИЧЭЭЛ: Шинжлэх ухаан, математик

